



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/09

Номгон

「 Төрийн байгууллагуудын олон нийтийг
хамруулан зохион байгуулах сургалт, семинар,
хурал зөвлөгөөнийг түр хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13, 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд коронавирусын халдварын тархалт буурахгүй өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан төрийн байгууллагуудын олон нийтийг хамруулан зохион байгуулах сургалт, семинар, хурал зөвлөгөөнийг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрөөс 2 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд түр хориглож,короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлсүгэй.

2.Төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд зохих журмын дагуу хяналт тавьж, нийтийг хамарсан арга хэмжээг дээрх хугацаанд бүрэн зогсоохыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Оюутболд), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж), аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал), сумдын Засаг дарга нарт, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр урьдчилан ажлыг зохион байгуулалтын өндөр түвшинд хийж гүйцэтгэхийг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (Хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

601220019